

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/27/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Долгорсүрэн  
Утас: 261885 Цахим хаяг: [dolgorsurenb@audit.gov.mn](mailto:dolgorsurenb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: П.Амарсанаа  
Утас: 261628 Цахим хаяг: [amarsanaap@audit.gov.mn](mailto:amarsanaap@audit.gov.mn)  
Б энд С аудит ХХК-ийн захирал: Д.Заяажаргал  
Утас: 99050268 Цахим хаяг: [bcauditllc@gmail.com](mailto:bcauditllc@gmail.com)  
Аудитор: Б.Пүрэвсүрэн  
Утас: 99075081 Цахим хаяг: [bcauditllc@gmail.com](mailto:bcauditllc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГАЗАР ИВЭЭЛ ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Б.ЭНХ-ОРГИЛ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/711

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Газар ивээл ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний төлөвлөгөөг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд нийт 647.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн түүхий эд материалыг тендер зарлахгүйгээр шууд худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана", "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд ШШГЕГ-ын алба хаагчдыг нормын хувцсаар хангахаас гадна Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-д 474.6 сая төгрөгийн ажлын гутал нийлүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

## Аудитын гол асуудал

Тайлант онд ШШГЕГ-т 135.0 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлснээр тус байгууллагын цэвэр алдагдал 6.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 9.2 сая төгрөгөөр дутуу байна.

## Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэл 95.8 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын31	2023 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	154,890,478.58	3,150,527.45
1.1.2	Дансны авлага	16,090,000.00	156,333,015.95
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	10,000,000.00	4,625,080.80
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	124,694,800.80	265,828,396.60
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>305,675,279.38</b>	<b>429,937,020.80</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	161,207,163.38	152,995,315.24
1.2.2	Биет бус хөрөнгө	776,331.84	28,981.55
1.2.3	Биологийн хөрөнгө		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>161,983,495.22</b>	<b>153,024,296.79</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>467,658,774.60</b>	<b>582,961,317.59</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		48,597,310.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,498,894.05	74,836,116.44
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,498,894.05</b>	<b>123,433,426.44</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,498,894.05</b>	<b>123,433,426.44</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	209,570,029.00	209,570,029.00
2.3.2	Хувийн өмч		
2.3.3	Хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	256,589,851.55	249,957,862.15
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>466,159,880.55</b>	<b>459,527,891.15</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>467,658,774.60</b>	<b>582,961,317.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 дугаар сарын31	2023 оны 12 дугаар сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>930,138,999.98</b>	<b>1,165,054,450.88</b>
2	Борлуулалтын өртөг	653,337,811.29	890,823,650.76
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>276,801,188.69</b>	<b>274,230,800.12</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		598,582.43
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	338,363.65	80,084,308.37
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	105,990,515.82	211,926,244.34
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз ( гарз )		
17	Бусад ашиг ( алдагдал )	(125,150,902.56)	(135,000,000.00)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>45,998,133.96</b>	<b>7,987,446.58</b>
19	Орлогын татварын зардал	17,114,903.65	14,619,435.98
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>28,883,230.31</b>	<b>(6,631,989.40)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>28,883,230.31</b>	<b>(6,631,989.40)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз ( гарз )		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>28,883,230.31</b>	<b>(6,631,989.40)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын31	2023 оны 12 дугаар сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,016,199,400.00</b>	<b>1,226,580,293.28</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,016,049,400.00	1,141,316,880.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	150,000.00	85,263,413.28
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>886,681,877.16</b>	<b>1,251,835,518.12</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	205,153,045.02	293,305,084.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,309,482.38	3,740,228.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	577,512,894.50	835,016,913.54
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	654,550.00	5,253,949.34
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,590,000.00	16,044,600.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	77,636,497.26	30,392,484.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	18,825,408.00	68,082,257.95
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>129,517,522.84</b>	<b>(25,255,224.84)</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(16,396,500.00)</b>	<b>8,515,273.71</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,500,000.00</b>	<b>12,321,173.71</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,500,000.00	11,722,591.28
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		598,582.43
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>18,896,500.00</b>	<b>3,805,900.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,396,500.00	1,930,900.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	12,500,000.00	1,875,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,396,500.00)</b>	<b>8,515,273.71</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(130,000,000.00)</b>	<b>(135,000,000.00)</b>
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>130,000,000.00</b>	<b>135,000,000.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	130,000,000.00	135,000,000.00
3.2.5	<b>Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал</b>		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>130,000,000.00</b>	<b>- 135,000,000.00</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(16,878,977.16)</b>	<b>(151,739,951.13)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>171,769,455.74</b>	<b>154,890,478.58</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>154,890,478.58</b>	<b>3,150,527.45</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	227,706,621.24	437,276,650.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
3	Залруулсан үлдэгдэл	209,570,029.00	227,706,621.24	437,276,650.24
4	Бусад дэлгэрэнгүй орлого			-
5	Өмчид гаргасан өөрчлөлт			-
6	Зарласан ногдол ашиг			-
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )		28,883,230.31	28,883,230.31
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	256,589,851.55	466,159,880.55
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
11	Залруулсан үлдэгдэл	209,570,029.00	256,589,851.55	466,159,880.55
12	Бусад дэлгэрэнгүй орлого			-
13	Өмчид гаргасан өөрчлөлт			-
14	Зарласан ногдол ашиг			-
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )		(6,631,989.40)	(6,631,989.40)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	249,957,862.15	459,527,891.15

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	<b>1,013,250.0</b>	<b>1,245,737.3</b>	<b>(232,487.3)</b>	<b>122.9</b>
1.1	Үүнээс: Цэвэр борлуулалт /нөат-гүй/	1,013,250.0	1,165,054.5	(151,804.5)	115.0
1.2	а. Борлуулалтын орлого-гутал, арьсан эдлэл	929,250.0	1,063,557.1	(134,307.1)	114.5
1.3	б. Борлуулалтын орлого-сүлжмэл	84,000.0	101,497.4	(17,497.4)	120.8
1.4	Бусад орлого	-	80,682.9	(80,682.9)	-
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	<b>1,010,388.8</b>	<b>1,100,488.5</b>	<b>(90,099.6)</b>	<b>108.9</b>
2.1	Цалин хөлс	82,743.7	117,410.9	(34,667.3)	141.9
2.2	ЭМД	1,654.9	2,636.1	(981.2)	159.3
2.3	Алба хаагчийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламж дэмжлэг	17,453.2	19,961.0	(2,507.9)	114.4
2.4	Хоригдлын цалин	42,800.0	109,694.9	(66,894.9)	256.3
2.5	Албан татвар хураамж /Машин татвар, бусад/	1,007.3	163.6	843.7	16.2
2.6	Бичиг хэргийн зардал	2,650.0	3,483.2	(833.2)	131.4
2.7	Ашиглалтын зардал	1,392.9	-	1,392.9	-
2.8	ТЭМ зардал	666,559.6	778,867.3	(112,307.7)	116.8
2.9	Санхүүгийн программын үйлчилгээний төлбөр	560.0	554.5	5.5	99.0
2.10	Бусад зардал	-	1,918.2	(1,918.2)	-
2.11	Шатахууны зардал	4,786.4	7,494.6	(2,708.2)	156.6
2.12	Шуудан холбоо, интернэт	660.0	2,393.1	(1,733.1)	362.6
2.13	Хүнс	4,640.0	6,884.8	(2,244.8)	148.4
2.14	Урсгал засварын зардал	1,160.0	1,346.1	(186.1)	116.0
2.15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	3,300.0	11,730.2	(8,430.2)	355.5
2.16	Цэвэрлэгээний материал	-	180.3	(180.3)	-
2.17	Томилолтын зардал	-	14,157.7	(14,157.7)	-
2.19	Элэгдлийн зардал	15,864.0	19,841.6	(3,977.6)	125.1
2.20	Хандив тусламж	-	928.4	(928.4)	-
2.21	Сэлбэг хэрэгсэл	842.0	842.0	-	100.0
2.22	Дээд байгууллагад төвлөрүүлэх орлого	135,000.0	135,000.0	-	100.0
2.23	Машин тоног төхөөрөмж	23,200.0	-	23,200.0	-
2.24	Тавилга эд хогшил	4,115.0	-	4,115.0	-
<b>3</b>	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>2,861.2</b>	<b>145,248.9</b>	<b>(142,387.7)</b>	<b>5,076.6</b>
	Орлогын татварын зардал	286.1	14,619.4	(14,333.3)	5,109.5
4	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>2,575.0</b>	<b>(4,370.6)</b>	<b>6,945.6</b>	<b>(169.7)</b>
5	<b>Хөрөнгө оруулалтын зардал</b>	<b>31,915.0</b>	<b>50,000.0</b>	<b>(18,085.0)</b>	<b>156.7</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 46.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Борлуулалтын тээврийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт шингээж бичилт хийсэн	1	3.0			1	3.0	1	3.0				
Үндсэн хөрөнгийн капиталжих зардлыг хангамжийн материалын дансанд бүртгэсэн	1	29.8			1	29.8	1	29.8				
Томилолтын зардлыг бүтээгдэхүүний өртөгт шингээж бичилт хийсэн	1	14.1			1	14.1	1	14.1				
Дүн	3	46.9			3	46.9	3	46.9				

Аудитаар нийт 651.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 649.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т гутал нийлүүлэх ажлын талаар танилцуулга хийх зорилгоор 2023 оны 6 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд ажилласан	1	2.0	1	2.0								

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

боловч 5 хоногийн дараа дахин өөртөө болон үйлдвэрийн нийт бие бүрэлдэхүүнд байгууллагын дарга тушаал гарган албан томиллолтоор ажиллаж, үр ашиггүй зардал гаргасан												
Бараа материалын дансыг нэр төрлөөр нь ангилаан бүртгэдэггүй, анхан шатны баримтын түвшин дэх хяналт хангалтгүй байна.	1						1					
Бараа материалын дансанд 2018 оноос хойш ашиглагдахгүй 300 ширхэг эмэгтэй албан хаагчдын гутлын ул бүртгэлтэй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй	1	2.0			1	2.0						
Үйлдвэрлэлийн бүх түүхий эд материалыг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг мөрдөөгүй, тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	647.1			1	647.1						
Дүн	4	651.1	1	2.0	2	649.1	1					

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 798.2 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны тайланд орлогын 74.6 сая төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 76.5 сая төгрөгийн 7 гүйлгээг ил тод тайлагнаж мэдээлээгүй байна. Өмнөх оны аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь мэдээлэх, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж өгсөн хэрэгжээгүй	1	151.1			1	151.1		
Дүн	1	151.1			1	151.1		
Нийт дүн	1	151.1			1	151.1		